48

Дүгүй

МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: (976-51) 26-35-06.
Цахим шуудан: info@mimr.gov.mn
цахим хуудас: www.mimr.gov.mn

2024.08.22 № 01/225

танай 2024.07.30-ны № 06 -т

Асуулгын хариу хүргүүлэх тухай

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Э.БОЛОРМАА ТАНАА

Танаас ирүүлсэн Ховд аймгийн Дарви сумын нутагт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа "Тефис майнинг" ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой асуулгатай танилцаад эрхлэх асуудлын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газар, Ховд аймгийн Засаг даргын тамгын газраас холбогдох мэдээллийг авч нэгтгэн хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Асуулга нэг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хариулт: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний талаарх асуудал нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхлэх асуудал байх бөгөөд энэ талаар манай яаманд тодорхой мэдээлэл байхгүй тул дэлгэрэнгүй мэдээллийг хариуцсан яаманд хандан авах нь зүйтэй байна.

Асуулга хоёр. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн талаар

2.1. Олборлож буй түүхий нүүрсээр баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа эсэх:

Хариулт: Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.1-д "тухайн ордыг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг эрх бүхий байгууллагаар хийлгэж ашиглалтын тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг жилийн дотор" гэж заасны дагуу Ховд аймгийн Дарви сумын нутагт орших "Тефис майнинг" ХХК-ийн Зүүн Хөшөөтийн нүүрсний ордыг ашиглах Техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн Т/167 тоот тушаалаар хүлээн авсан байна. Техник, эдийн засгийн үндэслэлд бүс нутгийн усны нөөц хангалтгүйг харгалзан хуурай аргаар баяжуулах технологийг тусгасан байна.

2.2. Бүтээгдэхүүн олборлож үйлдвэрлээгүй бол Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь заалтыг хэрэгжүүлж буй эсэх:

1508:06 0228

Хариулт: Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-т ""ашигт малтмалын ордын нөөц" гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг" гэж, 35 дугаар зүйлийн 35.5-д "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно." гэж тус тус заасан.

Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ийн 2.2-т "Ашигт малтмалын ордын нөөцийг нөлөөлөх хүчин зүйлсээс хамааруулж геологийн нөөц, үйлдвэрлэлийн нөөц гэж ангилна" гэж, 2.4-т "Геологийн баттай (А), бодитой (В), боломжтой (С-III, IV бүлэг) нөөцөд тулгуурлан ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах боломжтой. Үүний үр дүнд ордын нөөцийг бүхэлд нь буюу хэсэгчлэн олборлож болох уурхайн хил хязгаар дотор орших, хаягдал бохирдлыг тооцоолсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг батлагдсан (А'), магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөц гэнэ" гэж тус тус заасан.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дээр дурдсан хууль тогтоомжид заасны дагуу орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, тус яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, бүртгүүлэхийн зэрэгцээ Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6-д заасан мэдээллүүдийг агуулсан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны жил бүрийн тайлан, төлөвлөгөөг боловсруулан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж баталгаажуулах ажлыг гүйцэтгэх үүрэгтэй байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, уул уурхайн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэнээр "Тефис майнинг" ХХК нь 2023 оны үйл ажиллагааны тайланг тус газарт хүргүүлж, хянуулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд тухайн компани өнгөрсөн онд 75.5 мян.м^3 хөрс хуулж, 34.2 мян.тн нүүрс олборлож, 148.78 мян.тн нүүрс экспортод гаргаж улс, орон нутгийн төсөвт 6,318.6 сая төгрөгийн татвар хураамжийг төвлөрүүлсэн байна.

Асуулга гурав. Нутгийн захиргааны байгууллага, иргэн хоорондын хамтын ажиллагааны талаар

3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан эсэх:

Хариулт: "Тефис майнинг" ХХК-ийн тусгай зөвшөөрөл нь Ховд аймгийн Дарви, Цэцэг сумын нутгийг дамнан оршдог ордыг ашиглах эрх бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар хэсгийн 42.1 дэх заалтын дагуу Ховд аймаг, түүнийг төлөөлж аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, нөгөө талаас ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Тефис майнинг" ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Д.Чанцал нар харилцан тохиролцож, 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр "Байгаль орчныг хамгаалах, уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтран ажиллах

50

Хариулт: Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25-т ""ашигт малтмалын ордын нөөц" гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг" гэж, 35 дугаар зүйлийн 35.5-д "Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно." гэж тус тус заасан.

Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар"-ийн 2.2-т "Ашигт малтмалын ордын нөөцийг нөлөөлөх хүчин зүйлсээс хамааруулж геологийн нөөц, үйлдвэрлэлийн нөөц гэж ангилна" гэж, 2.4-т "Геологийн баттай (А), бодитой (В), боломжтой (С-III, IV бүлэг) нөөцөд тулгуурлан ордыг ашиглах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах боломжтой. Үүний үр дүнд ордын нөөцийг бүхэлд нь буюу хэсэгчлэн олборлож болох уурхайн хил хязгаар дотор орших, хаягдал бохирдлыг тооцоолсон эдийн засгийн хувьд үр ашигтай нөөцийг батлагдсан (А'), магадалсан (В') үйлдвэрлэлийн нөөц гэнэ" гэж тус тус заасан.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дээр дурдсан хууль тогтоомжид заасны дагуу орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, тус яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, бүртгүүлэхийн зэрэгцээ Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6-д заасан мэдээллүүдийг агуулсан үйлдвэрлэлийн үйл ажиллагааны жил бүрийн тайлан, төлөвлөгөөг боловсруулан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж баталгаажуулах ажлыг гүйцэтгэх үүрэгтэй байна.

Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, уул уурхайн мэдээллийн нэгдсэн системд бүртгэгдсэнээр "Тефис майнинг" ХХК нь 2023 оны үйл ажиллагааны тайланг тус газарт хүргүүлж, хянуулах ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд тухайн компани өнгөрсөн онд 75.5 мян.м^3 хөрс хуулж, 34.2 мян.тн нүүрс олборлож, 148.78 мян.тн нүүрс экспортод гаргаж улс, орон нутгийн төсөвт 6,318.6 сая төгрөгийн татвар хураамжийг төвлөрүүлсэн байна.

Асуулга гурав. Нутгийн захиргааны байгууллага, иргэн хоорондын хамтын ажиллагааны талаар

3.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан эсэх:

Хариулт: "Тефис майнинг" ХХК-ийн тусгай зөвшөөрөл нь Ховд аймгийн Дарви, Цэцэг сумын нутгийг дамнан оршдог ордыг ашиглах эрх бөгөөд Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар хэсгийн 42.1 дэх заалтын дагуу Ховд аймаг, түүнийг төлөөлж аймгийн Засаг дарга Б.Дүгэржав, нөгөө талаас ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Тефис майнинг" ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Д.Чанцал нар харилцан тохиролцож, 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр "Байгаль орчныг хамгаалах, уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтран ажиллах

51

гэрээ"-г байгуулсан байна. Уг гэрээ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж гэрээний хэрэгжилтийг 90%-тай гэж Ховд аймгийн засаг даргаас дүгнэсэн байна. /Гэрээг хавсаргав./

3.2. Гэрээ ил тод байгаа эсэх, байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх, дэд бүтэц тавих, ажлын байр, хандив тусламжийн асуудлаар гэрээнд хэрхэн туссан эсэх:

Хариулт: Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4-т "Нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан энэ хуулийн 42.1-д заасан гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана" гэж заасан байдаг. "Тефис майнинг" ХХК-ийн 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан гэрээний "Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг"-т Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасан байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

Үйлдвэрлэлд шаардлагатай цахилгаан, усан хангамжийн дэд бүтцийг барьж байгуулах;

Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

Ашиглалтын эхний 1-2 жилүүдэд нийт ажлын байрны 50 хувиас, 3 дахь жилээс 70 хувиас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;

Нийгмийн хариуцлагын хүрээнд бараа ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох;

Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

Зохих хууль тогтоомжийн дагуу уурхайд ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл болон нөлөөллийн сумдын иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулах.

3.3. Тусгай зөвшөөрөлд заагдсан газар нутагт амьдарч буй иргэдтэй олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх:

Хариулт: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын мэдээлснээр тусгай зөвшөөрлийн нөлөөллийн сумд болох Дарви, Цэцэг сумын багуудад амьдарч буй иргэд, олон нийтэд компанийн үйл ажиллагааг танилцуулах зорилгоор багийн

52

хуралд хэлэлцүүлэгт оролцож сум, багийн удирдлагуудтай байнга хамтран ажиллаж байна.

3.4. Нутгийн иргэдээс хэдэн хүнийг, ямар цалин хөлстэй ажиллуулж буй судалгаа:

Хариулт: Ховд аймгийн Засаг даргын тамгын газрын ирүүлсэн мэдээлд дурдсанаар төсөлд одоогийн байдлаар хөрс хуулалтын 2, тэсэлгээний ажил, үйлчилгээний 2, харуул хамгаалалтын 1 компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа бөгөөд уурхайд шаардлагатай ажлын байрны зарыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраар дамжуулан нийтэд зарлуулах ажлыг гүйцэтгэж байна. Төслийн хэмжээнд өнөөгийн байдлаар 560 гаруй ажилтан ажиллаж байгаагийн 390 ажилтан буюу 70 хувь нь орон нутгийн иргэд байх ба тэдгээрийн дундаж цалин 1.8-3.0 сая төгрөг байна.

Хавсралт 25 хуудастай.

САЙД Ц.ТУВААН